



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/148/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2025.02.11</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Аудитор: А.Адилзаяа Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p>
-------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	13
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	16
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	16
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	16
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	16
Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно .....	16
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	16
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.</b> .....	17
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	17
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	17
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	18
<b>7.ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b> .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Пүвсэндэнзавханцэнтийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дугаар баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/5  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд нийт 138 ажил төлөвлөснөөс хэрэгжилтийн хувь 80.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл

5020299

d:\2025 он\бичиг хэрэг\тоот\2. а4-албан тоот.docx

ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨР ГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>160,980,451.57</u></b>	<b><u>194,173,255.57</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	26,543,111.21	37,220,340.21
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	26,543,111.21	37,220,340.21
3351	Байгууллагаас авах авлага	26,543,111.21	37,220,340.21
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	134,437,340.36	156,952,915.36
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	21,564,733.25	26,582,533.25
35110	Тусгай зориулалттай материал	19,302,733.25	24,240,733.25
35130	Эм боох материал	2,262,000.00	2,341,800.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	107,194,832.11	130,370,382.11
35410	Бичиг хэргийн материал	1,908,450.00	1,603,450.00
35420	Аж ахуйн материал	40,979,382.11	76,747,832.11
35430	Сэлбэг хэрэгсэл	284,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	00.00	2,382,000.00
35470	Бусад хангамжийн материал	64,023,000.00	49,637,100.00
35600	Мал амьтад	5,677,775.00	00.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,595,722,978.68</u></b>	<b><u>2,951,819,192.27</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,595,722,978.68	2,951,819,192.27
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,566,289,645.40	2,922,719,192.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,409,858,059.28	2,449,120,346.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-340,395,945.57	-445,318,633.25
39203	Авто-тээврийн хэрэгсэл	233,674,425.00	452,527,402.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	-182,621,066.40	-173,944,374.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	300,713,517.00	281,652,732.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-180,677,784.73	-158,348,930.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	107,785,564.00	114,178,938.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-74,391,006.05	-77,379,680.71
39214	Бусад үндсэн хөрөнгө	526,695,950.00	733,718,960.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-235,481,567.13	-254,617,068.80
39217	Ном	1,129,500.00	1,129,500.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	29,433,333.28	29,099,999.92
39301	Програм хангамж	2,950,000.00	2,950,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,616,666.72	-1,950,000.08
39303	Бусад биет бус хөрөнгө	28,100,000.00	28,100,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,756,703,430.25</u></b>	<b><u>3,145,992,447.84</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>831,191.72</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	831,191.72
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	831,191.72
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	831,191.72

Гурванбулаг сумын Засаг Даргын Тамгын Газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,756,703,430.25</b>	<b>3,145,161,256.12</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,756,703,430.25	3,145,161,256.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	230,672,223.16	230,672,223.16
51101	Өмч: - төрийн	230,672,223.16	230,672,223.16
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,509,231,709.13	2,898,487,248.00
51210	Өмнөх үеийн үр дүн	2,509,231,709.13	2,510,029,422.13
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	388,457,825.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,799,497.96	16,001,784.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,756,703,430.25</b>	<b>3,145,992,447.84</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,268,791,071.46</b>	<b>2,078,703,229.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>283,614,515.25</b>	<b>786,687,387.60</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	283,614,515.25	786,687,387.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,052,805.00	10,019,552.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,052,805.00	10,019,552.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>985,176,556.21</b>	<b>1,292,015,842.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	33,096,756.21	151,053,342.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,633,645.00	63,223,230.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,463,111.21	87,830,112.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	952,079,800.00	1,140,962,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	952,079,800.00	1,140,962,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,218,535,575.74</b>	<b>1,546,118,922.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,218,535,575.74</b>	<b>1,546,118,922.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,085,925,913.31	1,387,153,631.95
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	444,775,040.00	640,075,213.49
210101	Үндсэн цалин	305,723,582.00	413,321,049.10
210102	Нэмэгдэл	101,623,403.00	200,104,664.39
210104	Урамшуулал	37,428,055.00	26,649,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	55,839,060.44	80,181,263.98
210201	Тэтгэврийн даатгал	38,012,786.30	54,473,931.55
210202	Тэтгэмжийн даатгал	4,456,564.36	6,400,836.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,565,251.40	3,304,406.26
210204	Ажилгүйдлийн даатгал	891,312.96	3,200,418.07
210205	Эрүүл мэндийн даатгал	8,913,145.42	12,801,672.07

Гурванбулаг сумын Засаг Даргын Тамгын Газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	61,567,604.73	79,632,942.11
210301	Гэрэл, цахилгаан	30,124,095.33	11,689,383.61
210302	Түлш, халаалт	31,443,509.40	67,943,558.50
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	136,198,211.40	77,537,227.00
210401	Бичиг хэрэг	4,811,940.00	3,197,100.00
210402	Тээвэр, шатахуун	47,145,435.00	48,150,232.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,247,786.40	2,273,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,440,800.00	8,110,120.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	62,808,350.00	3,970,500.00
210408	Бараа материал акталсны зардал	8,743,900.00	11,836,075.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,502,900.00	58,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,901,000.00	00.00
210502	Хоол, хүнс	1,601,900.00	58,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	19,273,350.00	20,048,270.00
210604	Урсгал засвар	19,273,350.00	20,048,270.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	18,377,600.00	14,135,700.00
210702	Дотоод албан томилолт	18,377,600.00	14,135,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	23,134,908.21	21,071,685.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,257,433.21	16,348,886.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	287,775.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	610,700.00	1,994,298.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	143,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	891,000.00	1,485,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	323,257,238.53	454,413,329.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	105,549,242.00	204,118,173.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	217,707,996.53	250,295,156.47
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	132,609,662.43	158,965,290.24
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,930,000.00	43,228,404.40
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	42,588,404.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,930,000.00	640,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	127,679,662.43	115,736,885.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	127,679,662.43	115,736,885.84
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>50,255,495.72</b>	<b>532,584,307.41</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	144,126,481.54
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,730,765.54
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	141,395,716.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	00.00	-144,126,481.54
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>50,255,495.72</b>	<b>388,457,825.87</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>995,229,361.21</b>	<b>1,328,578,505.21</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,052,805.00</b>	<b>10,019,552.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	10,052,805.00	10,019,552.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	10,052,805.00	10,019,552.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,052,805.00	10,019,552.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>985,176,556.21</b>	<b>1,318,558,953.21</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	33,096,756.21	177,596,453.21
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,633,645.00	63,223,230.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,463,111.21	114,373,223.21
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	952,079,800.00	1,140,962,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	952,079,800.00	1,140,962,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>974,086,361.21</b>	<b>1,309,458,755.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>974,086,361.21</b>	<b>1,309,458,755.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>816,193,587.57</b>	<b>1,108,041,079.16</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	445,867,733.30	639,837,858.28
210101	Үндсэн цалин	290,530,377.61	366,464,389.56
210102	Нэмэгдэл	122,557,062.21	246,995,942.10
210104	Урамшуулал	32,780,293.48	26,377,526.62
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	54,614,367.14	80,503,009.19
210201	Тэтгэврийн даатгал	37,137,258.90	54,719,676.76
210202	Тэтгэмжийн даатгал	4,368,924.80	6,400,836.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,495,699.80	3,380,406.26
210204	Ажилгүйдлийн даатгал	873,925.00	3,200,418.07
210205	Эрүүл мэндийн даатгал	8,738,558.64	12,801,672.07
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	68,643,491.13	79,079,310.39
210301	Гэрэл, цахилгаан	6,679,046.46	10,876,850.39
210302	Түлш, халаалт	61,964,444.67	67,924,900.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	277,560.00

Гурванбулаг сумын Засаг Даргын Тамгын Газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	42,515,672.00	39,607,530.00
210401	Бичиг хэрэг	3,779,700.00	3,234,400.00
210402	Тээвэр, шатахуун	29,503,632.00	21,714,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,117,140.00	1,181,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,234,500.00	12,171,230.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	880,700.00	1,305,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	21,261,550.00	23,169,070.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,375,000.00	1,550,000.00
210604	Урсгал засвар	19,886,550.00	21,619,070.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	18,377,600.00	13,599,700.00
210702	Дотоод албан томилолт	18,377,600.00	13,599,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,935,974.00	46,231,261.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,345,499.00	40,551,463.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	287,775.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	610,700.00	1,713,544.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,604,000.00	2,604,000.00
210807	Газрын төлбөр	00.00	130,254.40
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	151,977,200.00	186,013,339.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	151,977,200.00	186,013,339.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>157,892,773.64</b>	<b>201,417,676.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,500,000.00	48,460,450.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	47,320,450.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00	1,140,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	152,392,773.64	152,957,226.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	127,679,662.43	115,736,885.84
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>21,143,000.00</b>	<b>19,119,750.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>21,143,000.00</b>	<b>19,119,750.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>21,143,000.00</b>	<b>19,119,750.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	21,143,000.00	19,119,750.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,143,000.00	19,119,750.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-21,143,000.00</b>	<b>-19,119,750.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,746,223.16	82,853,327.20	920,364,474.90	1,221,964,025.26
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,746,223.16	82,853,327.20	920,364,474.90	1,221,964,025.26
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	29,490,792.03	29,490,792.03
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	2,509,231,709.13	2,756,703,430.25
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	2,509,231,709.13	2,756,703,430.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	797,713.00	797,713.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	2,510,029,422.13	2,757,501,143.25
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-797,713.00	00.00	-797,713.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	388,457,825.87	388,457,825.87
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	230,672,223.16	16,001,784.96	2,898,487,248.00	3,145,161,256.12

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,150,962,500.00	1,035,245,166.16	115,717,333.84	89.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,150,962,500.00	1,035,245,166.16	115,717,333.84	89.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,149,462,500.00	1,034,105,166.16	115,357,333.84	90.0

Гурванбулаг сумын Засаг Даргын Тамгын Газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	675,479,100.00	639,837,858.28	35,641,241.72	94.7
210101	Үндсэн цалин	381,903,700.00	366,464,389.56	15,439,310.44	96.0
210102	Нэмэгдэл	270,343,900.00	246,995,942.10	23,347,957.90	91.4
210104	Урамшуулал	23,231,500.00	26,377,526.62	-3,146,026.62	113.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	84,434,900.00	80,503,009.19	3,931,890.81	95.3
210201	Тэтгэврийн даатгал	57,415,700.00	54,719,676.76	2,696,023.24	95.3
210202	Тэтгэмжийн даатгал	6,754,800.00	6,400,836.03	353,963.97	94.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,377,400.00	3,380,406.26	-3,006.26	100.1
210204	Ажилгүйдлийн даатгал	3,377,400.00	3,200,418.07	176,981.93	94.8
210205	Эрүүл мэндийн даатгал	13,509,600.00	12,801,672.07	707,927.93	94.8
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	79,374,900.00	79,079,310.39	295,589.61	99.6
210301	Гэрэл, цахилгаан	10,450,000.00	10,876,850.39	-426,850.39	104.1
210302	Түлш, халаалт	67,924,900.00	67,924,900.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	277,560.00	722,440.00	27.8
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	41,679,200.00	39,607,530.00	2,071,670.00	95.0
210401	Бичиг хэрэг	3,306,400.00	3,234,400.00	72,000.00	97.8
210402	Тээвэр, шатахуун	21,800,000.00	21,714,900.00	85,100.00	99.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,369,400.00	1,181,600.00	187,800.00	86.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,500,000.00	12,171,230.00	1,328,770.00	90.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,703,400.00	1,305,400.00	398,000.00	76.6
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	49,900,000.00	42,288,820.00	7,611,180.00	84.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	7,169,750.00	1,830,250.00	79.7
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	35,900,000.00	30,119,070.00	5,780,930.00	83.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	13,609,000.00	13,599,700.00	9,300.00	99.9
210702	Дотоод албан томилолт	13,609,000.00	13,599,700.00	9,300.00	99.9

Гурванбулаг сумын Засаг Даргын Тамгын Газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,134,000.00	7,820,598.80	313,401.20	96.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,150,000.00	2,140,800.40	9,199.60	99.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,800,000.00	1,713,544.00	86,456.00	95.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	132,000.00	168,000.00	44.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,604,000.00	2,604,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	180,000.0	130,254.4	49,745.6	72.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	196,851,400.0	131,368,339.5	65,483,060.5	66.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	195,561,400.0	131,368,339.5	64,193,060.5	67.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,290,000.0	-	1,290,000.0	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,500,000.0	1,140,000.0	360,000.0	76.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,500,000.0	1,140,000.0	360,000.0	76.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.0	1,140,000.0	360,000.0	76.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,150,962,500.0	1,035,245,166.2	115,717,333.8	89.9
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,138,962,500.0	1,025,225,614.2	113,736,885.8	90.0
132001	Орон нутгийн төсвөөс	1,138,962,500.0	1,025,225,614.2	113,736,885.8	90.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	12,000,000.0	10,019,552.0	1,980,448.0	83.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,000,000.0	10,019,552.0	1,980,448.0	83.5
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	23	23	-	100.0
620001	Удирдах ажилтан	8	8	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	8.0	8.0	-	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЗДТГ нь оновчтой бодлого, төлөвлөлтөөр хэрэгжилтийг хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх тэргүүн зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод аудит/аудиторын чиг үүргийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба тайлант онд шалгалт хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 389,289.0 мянган төгрөг буюу 14.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	160,980.4	194,173.2	33,192.8
<b>АВЛАГА</b>	26,543.1	37,220.3	10,677.2
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	134,437.3	156,952.9	22,515.5
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,595,722.9	2,951,819.1	356,096.2
<b>Биет хөрөнгө</b>	2,566,289.6	2,922,719.1	356,429.5
Хуримтлагдсан элэгдэл	-1,015,184.0	-1,111,558.6	-96,374.6
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	2,756,703.4	3,145,992.4	389,289.0
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	831.1	831.1
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,756,703.4	3,145,161.2	388,457.8
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	2,756,703.4	3,145,992.4	389,289.0

Авлага дансны үлдэгдэл 37,220.3 болж оны эхний үлдэгдлээс 10,677.2 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл төвлөрүүлснийг авлагаар тусгасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 156,952.9 мянган төгрөг болж 22,515.5 мянган төгрөгөөр өссөн нь 41,497.5 мянган төгрөгийн аж ахуйн материал үнэ төлбөргүй хүлээн авч, 5,677.7 мянган төгрөгийн мал амьтан хорогдсоныг данснаас хассан нь голлох нөлөөг үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,951,819.1 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 356,096.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 19,119.7 мянга, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 195,379.7 мянга, Засгийн газрын 2024 оны 63 дугаар тогтоолоор 187,000.0 төгрөгийн автомашин, Гурванбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 154,815.3 мянга, Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 25-р захирамжаар 13,316.6 мянган төгрөгийн автомашин, тоног төхөөрөмж, 56-р захирамжаар аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас 32,466.6 мянга, 99-р захирамжаар 7,024.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлж орлогод авсан бол аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 38-р захирамжаар 156,651.2 төгрөгийн хөрөнгө акталж, данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,145,161.2 мянган төгрөг болж 388,457,825.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүн 388,457,825.8 мянган төгрөгийн өсөлт голлох нөлөөг үзүүлжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,138,962.5 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 12,000.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,150,962.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр 1,138,962.5 мянга, өөрийн үндсэн үйл ажиллагаанаас 12,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,025,225.6 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 10,019.5 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 140,376.1 мянга, урсгал үйл ажиллагаанд 1,175,621.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,035,245.2 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 89.9 хувийг зарцуулсан нь гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны зардлыг 53 хувиар, ажил олгогчоос олгох тэтгэмж арга хэмжээний зардлыг 32 хувиар хэмнэсэн нь голлох нөлөө үзүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглал</b>		1,150,962.5	1,035,245.17	115,717.33	89.9
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	785,611.90	737,978.81	47,633.09	93.9
2	80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	161,689.20	155,705.39	5,983.81	96.3
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,000.00	680.00	320.00	68.0
4	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	48,601.40	45,729.76	2,871.64	94.1
5	81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	37,460.00	34,901.55	2,558.45	93.2
6	82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах	12,600.00	11,331.23	1,268.77	89.9
7	82310 Гамшигаас сэргийлэх сургалт, сурталчилгаа	104,000.00	48,918.43	55,081.57	47.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 20,800.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий түлш, шатах тослох материал нийлүүлэх тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан бөгөөд НИК ХХК шалгарч 20,800.0 мянган төгрөгийн гэрээг 2024 оны 02-р сарын 13-нд байгуулан 2024.12.31-ныг хүртэлх хугацаанд шатахуун нийлүүлсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванбулаг сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар 17-ны өдрийн сарын 3/12 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв болох 1,150,962.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,509.6 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,056.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад 5 саяас дээш дүнтэй орлогын 1,251,955.3 мянган төгрөгийн 43 гүйлгээ, зарлагын 381,258.8 мянган төгрөгийн 29 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2023 оны санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэсэн бөгөөд тус аудитаар 1 албан шаардлага хүргүүлснээс биелэлт 100 хувь байна.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	-	1	-	100
Зөвлөмж	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 187,000.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 63-р тогтоолоор ОБЕГ-аас тус байгууллагад үнэ төлбөргүй ирсэн 187,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Toyota Hilux автомашиныг үндсэн хөрөнгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн байдлын тайлан болон үндсэн хөрөнгийн тайланд орхигдуулсан хөрөнгийг тусгаж, зарлуулав.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруул аагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засгийн газрын 2024 оны 63-р тогтоолоор ОБЕГ-аас тус байгууллагад үнэ төлбөргүй ирсэн 187,000,000 төгрөгийн үнэ бүхий Toyota Hilux автомашиныг үндсэн хөрөнгийн дансанд орлогод хүлээн зөвшөөрөөгүй байгаа нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.	1	187,000.0	1	187,000.0			1	187,000.0		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>187,000.0</b>	<b>1</b>	<b>187,000.0</b>			<b>1</b>	<b>187,000.0</b>		

## 7. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ					1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЭЗ								
	<b>НИЙТ</b>					<b>1</b>			

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----